

Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

(2016 оны 5 дугаар сарын байдлаар)

**I. Нийгмийн байдал****I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн**

Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 2016 оны 5 дугаар сард 303 байгаагийн 170 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 72 буюу 23.8 хувиар өсч, өмнөх сарынхаас 45 буюу 12.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Улсын бүртгэл, статистикийн газрын Бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 5 дугаар сарын байдлаар 183 эх амаржиж, 184 хүүхэд төрсөн нь өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 13 буюу 7.1 хувиар, төрсөн хүүхдийн тоо 13 буюу 7.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

**II. Нийгмийн даатгал, халамж**

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 5 дугаар сард 2745.0 сая төгрөг, зарлага 3576.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 433.6 сая төгрөг буюу 13.6 хувиар буурч, зарлага 45.5 сая төгрөг буюу 1.3 хувиар өслөө. Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 5 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 433.6 сая төгрөгөөр буурахад тэтгэврийн орлого 280.9 сая төгрөг буюу 14.1 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Нийгмийн халамжийн сангаас 2016 оны эхний 5 сард 3412 хүнд 563.3 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамж авагчдын тоо 161 хүн буюу 4.9 хувиар, олгосон нийгмийн халамжийн сан 1.9 сая төгрөг буюу 0.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

**III. Эрүүл мэнд**

Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2016 оны эхний 5 сарын байдлаар 186 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 185 үүнээс 84 нь хүү, 101 нь охин байна. Өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 16 буюу 9.4 хувиар, төрсөн хүүхэд 17 буюу 10.1 хувиар тус тус өссөн байна. Он гарсаар 60734 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 14581 буюу 31.6 хувиар, 2234 хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 357 буюу 19.0 хувиар тус тус өссөн байна. 2016 оны эхний 5 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 3130 удаа гарч, осол гэмтлийн өвчлөл 368, халдварт өвчин 163 бүртгэгдсэн байна.

IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 5 сард 91 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 4 буюу 4.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Илрээгүй гэмт хэргийн тоо 16, гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 67 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс илрээгүй гэмт хэрэг 8 буюу 33.3 хувиар буурсан, илрүүлэлтийн хувь 23.0 пунктээр өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн улмаас 53 хүн гэмтэж, 2 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 4 буюу 8.2 хувиар өссөн, нас баралт 1 буюу 33.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**Хэрэглээний үнийн индекс**

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2016 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас 5.9 хувь, өмнөх оны эцсийнхээс 3.0 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 0.8 хувиар өссөн байна. Ерөнхий индекс өмнөх оны мөн үеийнхээс 5.9 хувиар өсөхөд боловсролын үйлчилгээ 32.5 хувиар, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны бүлгийн үнэ 40.2 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

**VI. Орон нутгийн төсөв**

2016 оны эхний 5 сарын байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 6417.8 сая төгрөг, гүйцэтгэлээр 6816.7 сая төгрөг болж нь өмнөх оны мөн үеийнхээс төсвийн орлогын гүйцэтгэл 1957.1 сая төгрөг буюу 40.3 хувиар өсчээ. Аймгийн төсвийн нийт зарлага 6643.9 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 6410.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 233.6 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Төсвийн нийт зарлага өмнөх оны мөн үеийнхээс 1614.3 сая төгрөг буюу 33.6 хувиар өссөн байна. 2016 оны эхний 5 сарын байдлаар авлагын үлдэгдэл 25.0 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 442.2 сая төгрөг байна.

VII. Мал аж ахуй

Аймгийн хэмжээнд 2015 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 171188 хээлэгч малын 148358 буюу 86.6 хувь нь 2016 оны 5 дугаар сарын байдлаар төллөсөн байна. Эм хонины 90.9 хувь, эм ямаа 85.8 хувь, үнээний 70.1 хувь, ингэний 43.2 хувь, гүүний 56.8 хувь нь төллөжээ. Гарсан төлийн 149539 толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 20698 толгойгоор өссөн үзүүлэлттэй байна. 2016 оны эхний 5 сард том малын зүй бус хорогдол 10943 болж, өмнөх оны мөн үеийнхээс 10633 толгойгоор өссөн байна. Нийт хорогдолд өвчнөөр хорогдсон 2 мал байна.

**VIII. Аж үйлдвэр**

Аж үйлдвэрийн салбарын нийт гаргалт 2016 оны эхний 5 сард 18833.6 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 4518.9 сая төгрөг буюу 31.6 хувиар өссөн ба үүнд уул уурхайн салбарынх 4482.3 сая төг буюу 33.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Оны үнээр 18178.5 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1227.4 сая төгрөг буюу 7.2 хувиар өслөө.

Шивээ-Овоо ХК нь нийт борлуулалтын 17135.5 сая төг буюу 94.3 хувийг дангаараа бүрдүүлсэн байна.

Материал бэлтгэсэн: Гэрээт ажилтан.....Ү.Содномпил

